

47

“ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 04-р сарын 20-ны өдөр

№ 01

Дархан-Уул аймаг

Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон
санхүүгийн тайланг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ
НЬ:


1. “Дархан гурил тэжээл” ХК-ийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг баталсугай.
2. “Дархан гурил тэжээл” ХК-ийн үйлдвэрийн шинэчлэлийг 2015 оны эхний хагаст багтаан хийж дуусган, үйлдвэрийн үйл ажиллагааг эхлүүлэхийг Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.
3. “Дархан гурил тэжээл” ХК нь 2014 онд үндсэн үйлдвэрлэл явуулаагүй, орлогогүй алдагдалтай байгаа болон Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.1, 47.1.2 дугаар заалтад заасан нөхцлүүдийг хангахгүй байгаа тул Хувьцаа эзэмшигчдэд нөгдөл ашиг хуваарилахгүй байхаар тогтоосугай.

ХУРЛЫН ДАРГА


СОДГЭРЭЛ



ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Р.БОЛДБААТАР

48

“ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 04-р сарын 20-ны өдөр

№ 02

Дархан-Уул аймаг

Компанийг өөрчлөн байгуулах тухай

Компанийн тухай хуулийн 18, 23 дугаар зүйлүүд, 62 дугаар зүйлийн 62.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Дархан гурил тэжээл” ХК-ийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөн байгуулахыг зүйтэй гэж үзсүгэй.

2. “Дархан гурил тэжээл” ХК-ийг хязгаарлагдмал хариуцлагатай компани өөрчлөн байгуулах төсөл, төлөвлөгөө боловсруулах, санхүүгийн зохицуулах хорооноос зохих зөвшөөрөл авч, тус компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж батлуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

“Дархан гурил тэжээл” ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

Ш.Энхтөр

Ажлын хэсгийн гишүүд:

“Дархан гурил тэжээл” ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

Э.Одбаяр

“Дархан гурил тэжээл” ХК-ийн Гүйцэтгэх захирал

С.Намсрайжав

3. Энэ тогтоолын 2 дахь заалтад заасан төсөл, төлөвлөгөөг 2015 оны эхний хагаст багтаан хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж батлуулахыг ажлын хэсэгт даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Э.СОДГЭРЭЛ

ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Р.БОЛДБААТАР

“ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 4-р сарын 20-ны өдөр

№ 03

Дархан-Уул аймаг

Компанийн дүрэмд нэмэлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 62 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Дархан гурил тэжээл” ХК-ийн дүрмийн 2.1 дэх хэсэгт дор дурдсан агуулга бүхий 2.1.5, 2.1.6 дахь заалтуудыг нэмсүгэй. Үүнд:

- 1. “2.1.5. үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж угсрах, засварлах.”
- 2. “2.1.6. газар тариалан эрхлэх”

2. “Дархан гурил тэжээл” ХК-ийн дүрэмд оруулсан нэмэлтийг бүртгэлийн байгууллагад бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал С.Намсрайжавт даалгасугай.

3. Компанийн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн засварын хэсгийн ажилд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал С.Намсрайжавт үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Э.СОДГЭРЭЛ

ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Р.БОЛДБААТАР